

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ  
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 12 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.


Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**